



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2019 оны 01 сарын 22 өдөр

Дугаар 35

Улаанбаатар хот

Татан буугдсан хуулийн этгээдийн  
хөрөнгийг шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2018 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн “Хууль хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” 188 дугаар тогтоолын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Биокомбинат” төрийн өмчит үйлдвэрийн газар татан буугдаж байгаатай холбогдуулан компанийн хаалтын тайланд тусгагдсан нийт 7,771,152,242.08 (долоон тэрбум долоон зуун далан нэгэн сая нэг зуун тавин хоёр мянга хоёр зуун дөчин хоёр төгрөг найман мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий үндсэн болон эргэлтийн хөрөнгийг “Биокомбинат” улсын төсөвт үйлдвэрийн газарт шилжүүлсүгэй.

2. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, удирдлагын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т даалгасугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТ, УДИРДЛАГЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.ГАНБАТ

Ц.БАЯР-ЭРДЭНЭ